



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 03 өдөр

Дугаар 90

Хэрлэн сум

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын
Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт
хариуцсан ахлах мэргэжилтний сул орон тоонд
томилуулахаар нэр дэвшүүлэх тухай


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 5.7, 3.5, 3.5.4 дэх заалт, 2023 оны 25 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 12.1, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтад /70/ оноо авч, тэнцсэн Ганбатын Тунгалагийг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хөрөнгө оруулалт хариуцсан ахлах мэргэжилтний сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч Г.Тунгалагийг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг 30 хоногийн дотор гаргаж, албан бичгээр ирүүлэх шаардлагатайг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (С.Мөнхцэцэг)-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ш.Эрдэнэжаргал)-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР